



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/322

Мөрөн сум

Төрийн захиргааны албан хаагчдад
мөнгөн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Төрийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7, 51 дүгээр зүйлийн 51.3, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн орон нутгийн байгууллагуудын төрийн захиргааны албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад таван жил тутамд нэг удаа олгох урамшууллын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Мөнгөн урамшуулалд олгох зардлыг төрийн албан хаагчдад олгох мөнгөн тэтгэмж тусламжийн зардлаас шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох хууль, тогтоол журмын дагуу холбогдох баримт материалын бүрдлийг бүрэн зөв хангаж ажиллахыг төсөв захирагч нарт даалгасугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
06 дугаар сарын 24 ний өдрийн
А/324 дугаар захирамжийн
хавсралт

Төрийн захиргааны албан хаагчдад олгох мөнгөн
урамшууллын жагсаалт /сум, байгууллагаар/

(мян.төгрөг)

№	Байгууллага	Хүний тоо	Мөнгөн дүн
1	Аймгийн ЗДТГ	1	10,806.0
2	Байгаль орчин ,аялал жуулчлалын газар	5	29,018.0
3	Бүрэнтогтох сумын ЗДТГ	1	6,555.8
4	Баянзүрх сумын ЗДТГ	1	7,326.7
5	Түнэл сумын ЗДТГ	1	6,645.8
6	Галт сумын ЗДТГ	1	355.6
7	Цагаан-Үүр ЗДТГ	3	18,291.1
8	Цагаан-Уул сумын ЗДТГ	4	21,556.7
9	Цэцэрлэг сумын ЗДТГ	1	6,555.8
10	Чандмань-Өндөр сумын ИТХ	1	6,413.0
11	Хатгал тосгоны захирагчийн алба	1	7,380.0
Нийт дүн		20	120,904.5